



**Хэвлэлийн мэдээ**

2016 оны 5-р сарын 20-ний өдөр, Баасан гараг

**Холбогдох утас:**

9710-9009

**Монгол дахь Америкийн Худалдааны Танхим  
Оюу Толгой ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй уулзалт  
зохион байгууллаа**

2016 оны 5-р сарын 19-нд Монгол дахь Америкийн Худалдааны танхим (АмЧам) нь Оюу Толгой ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болох Гүйцэтгэх захирал ноён Эндрью Вүдлэй болон Гүний уурхайн төслийн захирал ноён Марко Пирэс нартай уулзалт зохион байгууллаа.

Уулзалтанд АмЧамын гишүүд болон бизнесийн бусад төлөөлөл болох 70 гаруй бизнес эрхлэгчид оролцож Оюу Толгойн ордын Гүний уурхайн бүтээн байгуулалт болон ханган нийлүүлэгчдийн бизнесийн боломжуудын талаар цогц, дэлгэрэнгүй мэдээлэл авсан юм.

Оюу Толгойн Гүний уурхайг хөгжүүлэх шийдвэр 2016 оны 5-р сарын 6-нд эцэслэн батлагдсанаар дэлхийн түвшний уурхайн бүтээн байгуулалтын хоёр дахь үе шат эхэлсэн билээ. Энэ шийдвэр нь “Рио Тинто”, Монгол Улсын Засгийн газар болон “Туркойз Хилл Ресурс” компаниудын уурхайг өргөтгөх 5.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх шийдвэр болон Гүний уурхайн бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд шаардлагатай бүх зөвшөөрлийг авсны дараагаар гарсан юм. Өргөтгөл хийснээр “Оюу толгой” компани жилд 500,000 тонн зэс үйлдвэрлэх хүчин чадалтай болох ба одоогоор жилд 175,000-200,000 тонн зэс үйлдвэрлэж байгаа. Мөн Гүний уурхайн бүтээн байгуулалтын хугацаанд газрын гадаргаас 1.3 километрийн гүнд нийтдээ 200 гаруй километр урт хонгил баригдах юм. Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажлын оргил үед гүний уурхайн төсөлд 3,000 хүн ажиллахын зэрэгцээ үндэсний ханган нийлүүлэгчидтэй тогтоосон нягт хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх ажээ. Мөн Гүний уурхайг бүрэн хүчин чадлаар ашиглаж эхэлснээр “Оюу толгой” нь дэлхийн хэмжээнд зэсийн хамгийн том таван уурхайн нэг болох юм.

Оюу Толгой ХХК-ийн Гүйцэтгэх захирал ноён Эндрью Вүдлэй уулзалтын үеэр хэлэхдээ “АмЧам Монголын адил Оюу Толгой компани бизнесийн өргөн хүрээний хөгжүүлэлтийг дэмжиж бас хамтарч ажилладаг. Оюу Толгой ХХК Монгол улсын эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж ажиллаж ирсэн” гэсэн юм.

Оюу Толгой ХХК-ийн Гүний уурхайн төслийн захирал ноён Марко Пирэс танилцуулгадаа “Ханган нийлүүлэгчид болон хамтран ажиллагсаддаа сонгохдоо бидний нэн түрүүнд хардаг зүйл бол аюулгүй байдал болон туршлага байдаг” гэсэн юм.

**АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.